



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.08.05 № 01/725
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТҮНЭЛ
СУМЫН АРДЧИЛСАН НАМЫН
ХОРООНЫ ДАРГА Д.ЦОГБАЯР
ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн Түнэл сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Хөвсгөл аймгийн Түнэл сумын Ардчилсан намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Хөвсгөл аймгийн Түнэл сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Хөвсгөл аймгийн Түнэл сумын Ардчилсан намын хорооны Хөвсгөл аймгийн Түнэл сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор

ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага болон холбогдох бусад хууль, тогтоомжид тус тус нийцсэн байна.

Хөвсгөл аймгийн Түнэл сумын Ардчилсан намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөр (4 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Хөвсгөл аймгийн Түнэл сумын Ардчилсан намын хороонд

Хувийг: Хөвсгөл аймгийн Түнэл сумын Сонгуулийн хороонд

Хавсралт . . . хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

ЕРӨНХИЙ АГУУЛГА:

“ХӨГЖСӨН ТҮНЭЛ” мөрийн хөтөлбөрөө сум орон нутгийнхаа онцлог, байгаль цаг уурын нөхцөл, хүн ардын амьдралын хэв маяг, хүрээлэн буй орчны нөлөөлөл зэргийг харгалзан хүн ардад ээлтэй, өрх гэр бүлийн үйлдвэрлэлийг дэмжсэн, хувь хүний хөгжилд чиглэсэн, уламжлалт өв соёлоо дээдэлсэн, хөдөө аж ахуйн үйл ажиллагаанд тулгуурласан, байгалийн нөөцөд түшиглэсэн, аялал жуулчлалыг хөгжүүлэх орон нутаг болно гэх эрхэм зорилгыг баримталж, иргэдийг амар тайван орчинд амьдруулахад чиглэнэ.

Тус сумын Ардчилсан намын хорооноос дэвшүүлж буй энэхүү мөрийн хөтөлбөр нь нутгийнхаа хөгжил дэвшлийн төлөө эрүүл мэнд, боловсрол, хууль эрх зүй, ээлтэй засаглал, хөдөө аж ахуй, худалдаа үйлчилгээ, бизнес зэрэг салбарт тулгамдаж буй асуудлуудыг НӨУБ-аар дамжуулан тогтоол, шийдвэр гарган Төрийн захиргааны байгууллагаар дамжуулан хэрэгжүүлэхэд оршино.

Хөтөлбөрийн үндсэн заалт

Нэг: АЖИЛТАЙ, ОРЛОГОТОЙ ИРГЭД


- 1.1. Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаагаар мал сүргийн эрүүл мэндийг хамгаалж, эрүүл аюулгүй хүнс, үйлдвэрлэх үндсэн нөхцөлийг бүрдүүлнэ.
- 1.2. Уст цэгийг түшиглэн, хүнсний ногоо тариалах талбайг нэмэгдүүлж, тоног төхөөрөмжөөр хангаж, сумын хүнсний ногооны /төмс/ хэрэгцээний тодорхой хувийг сумандаа шийдэх бодлого баримтална.
- 1.3. Ногоон тэжээл тариалах иргэдийн санал санаачилгыг дэмжиж, тоног төхөөрөмжөөр хангана.
- 1.4. Байгалийн нөөцийг /жимс,бусад ургамал/ боловсруулах, зах зээлд нийлүүлэх талаар сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах, бүтээгдэхүүнийг хадгалах, савлах савлагааны цехийг бий болгох ажлыг бодлогоор дэмжинэ.
- 1.5 Туслах аж ахуй /гахай,тахиа,зөгий/ эрхлэх иргэдийн санал санаачилгыг дэмжинэ.
- 1.6 Мах, сүү, цагаан идээг савлах, ангилах, эрүүл аюулгүй бүтээгдэхүүн үйлдвэрлэх цех бий болгоно.

Хоёр: ДЭД БҮТЭЦ-БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

- 2.1. Орон нутгийн зам давааг засаж сайжруулна.
- 2.2. Мөрөн-Түнэл сумыг холбосон хатуу хучилттай замыг шийдвэрлүүлнэ.
- 2.3. Сумын төв доторх бетонон замыг барьж байгуулна.
- 2.4. Гудамж талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлж, айл бүр гэрэлтэй байх арга хэмжээг зохион байгуулна.
- 2.5. Сумын төвийн камержуулалтыг нэмэгдүүлэх, албан байгууллагуудыг бүрэн камержуулна.
- 2.6. Сумын төвийн төв замаар явган хүний зам тавина.
- 2.7. Түнэл сумын цахилгаан эрчим хүчний шугам, дулааны шугам сүлжээнд өргөтгөл хийх, тогоог шинэчилж, томруулах, хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлыг шийдвэрлүүлж ажиллана.
- 2.8. Суманд чанарын стандарт хангасан спорт заал бариулна.

Гурав: ХӨДӨӨ, АЖ АХУЙГ ХӨГЖҮҮЛЭХ

- 3.1.Бэлчээрийн менежментийн төлөвлөгөө боловсруулна.



0000000000

3.2. Малын үүлдэрлэг байдал чанарт анхаарч, сүргийн бүтцийг сайжруулах, хээлтэгч, хээлтүүлэгчийн зохистой харилцааг бий болгоно.

3.3. Цөөн малтай, залуу малчин өрхийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн "Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-т болон бусад Олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрт хамруулах ажлыг зохион байгуулна.

3.4. "Чинээлэг малчин хөтөлбөр"-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

3.5. Малын гаралтай түүхий эдийг боловсруулах, зах зээлд нийлүүлэх боловсруулалтын нэгдсэн сүлжээг бий болгох кластерын бүтцийн ажлыг үргэлжлүүлнэ.

3.6. Бэлчээрийн нөөцийн менежментийг сайжруулах, алсын бэлчээр ашиглалтыг нэмэгдүүлэх бодлого баримталж отор нүүдэл хийсэн айл өрхөд дэмжлэг үзүүлэх бодлого баримтална.

3.7. Төмс, хүнсний ногооны тариалалт, хураалтыг дэмжиж хадгалах нөөцийг сайжруулах стандартад нийцсэн зоорь барих хувийн хэвшлийн санаачилгыг дэмжиж ажиллана.

Дөрөв: ИРГЭНД ЭЭЛТЭЙ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

4.1. Сумын хөгжлийн урт хугацааны төлөвлөгөөг шинэчлэн батална.

4.2. Төрийн байгууллагуудын албан хаагчдын хүнд суртлыг арилгах, ИРГЭНД ЭЭЛТЭЙ төрийн үйлчилгээг бий болгоно.

4.3. Их, дээд сургууль төгссөн сумын харьяалалтай залуусыг сумын төрийн албанд ажиллуулах бодлогыг баримталж, дэмжиж ажиллана.

4.4. Сумаас их, дээд сургуульд элсэн суралцаж буй оюутнуудыг дэмжиж ажиллах, бөгөөд сумандаа дадлага хийх, улмаар сум орон нутагтаа эргэн ажиллах боломжийг бүрдүүлэхээр ажиллана.

4.5. Төрийн албан хаагчдыг чадавхжуулах сургалтад шат дараатайгаар хамруулна.

Тав: БАГ, БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖИЛ

5.1. Багийн төвүүдийг шинэчлэх, тохижилтыг сайжруулна.

5.2. Багуудад бэлчээрийн усан хангамжийг сайжруулах дэс дараатай арга хэмжээг хэрэгжүүлэн, бэлчээр менежментийн төслийг үр дүнтэй хэрэгжүүлнэ.

5.3. Хүн эмнэлгийн тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх, эмч, эмнэлгийн ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх санал санаачилгыг дэмжинэ.

5.4. Эх хүүхдийн эрүүл мэндэд анхаарч, зорилтот бүлгийн хүүхдийг зуны сувилалд хамруулах, зуны гэр цэцэрлэгт малчдын хүүхдийг хамруулахад анхаарч ажиллана.

5.5. Хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх, авьяас чадварыг хөгжүүлэх, хүүхдэд ээлтэй орчин нөхцөл бий болгох санал санаачилгыг дэмжиж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.


5.6. Аймаг бүс, олон улсад амжилт гаргасан албан хаагчид, сурагчид, иргэд болон жил бүр элсэлтийн ерөнхий шалгалтад 700-гаас дээш оноо авсан багш сурагчдыг урамшуулна.

5.7. Соёл урлаг, соён гэгээрүүлэх чиглэлийн арга хэмжээг зохион байгуулах, соёлын үйлчилгээний нэр төрөл, чанарыг нэмэгдүүлнэ.

5.8. Төрийн албан хаагчдын харилцаа хандлага, ур чадварыг нэмэгдүүлэх, шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах, өөрийгөө хөгжүүлэх боломжийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана.



0000000003



5.9. ЕБС-ийн барилгыг шинэчлэх ажлыг холбогдох байгууллагаар дамжуулж, шийдвэрлүүлэн ажиллана.

Зургаа: СУМЫН БРЕНД-ӨРХ, ААН-ҮҮДИЙН ОРЛОГО

6.1. Мод хатаалга боловсруулах үйлдвэр байгуулах, нэмүү өртөг шингээж, зах зээлд нийлүүлэх, эцсийн бүтээгдэхүүн болгон зах зээлд гаргах арга хэмжээг бодлогоор дэмжинэ.

6.2. Орон нутагт гэрийн мод үйлдвэрлэл, мужаан цех бий болгох санал санаачилгыг дэмжинэ.

6.3. Сумын брэнд бий болгон ажиллаж буй өрх, хоршоо, ААН-үүдийн бодлогоор дэмжинэ.

6.4. Аялал жуулчлалын отог байгуулах, жуулчдын урсгалыг нэмэгдүүлэх, тэдэнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ. Энэ төрлийн санал санаачилгыг дэмжиж ажиллана.

Долоо: БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН АРГА ХЭМЖЭЭ

7.1. Сумын биеийн тамирын арга зүйч багшийг бодлогоор дэмжиж, иргэдийн дундах нийтийн биеийн тамирын арга хэмжээг хөгжүүлнэ.

7.2. Сумын төрийн албан хаагчдын дундах спортын арга хэмжээг чанаржуулж, аймаг бүсийн хэмжээнд зохион байгуулж, авьяас, амжилтаараа манлайлсан албан хаагчдыг урамшуулах арга хэмжээг зохион байгуулна.

7.3. Спортын олон төрөлт дугуйлан, секц явуулж буй багш, мэргэжилтнүүдийг дэмжиж, урамшуулна.

7.4. Спортын олон төрөлд холбоо, клуб болон үндэсний спортын холбоод болох морь, бөх, сур, шагайг бодлогоор хөгжүүлж, дэмжинэ.

Найм: БАЙГАЛЬ ОРЧИН-НОГООН ХӨГЖИЛ


8.1. Айл өрхийг жил бүр мод тариулах арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулж ажиллана.

8.2. хашаандаа сайхан амьдаръя арга хэмжээг үртэй дүнтэй зохион байгуулна.

8.3. Нийгмийн хариуцлагын хүрээнд сумандаа мод тарь ургуулан хүлээлгэж өгсөн иргэн, ААН-үүдийг бодлогоор дэмжиж, урамшуулдаг болно.

8.4. Байгаль орчинтой зөв зохистой харилцах талаар иргэдийн дундах сургалт, эрх зүйн арга хэмжээг шат дараатай зохион байгуулна.

8.5. "ХОГГҮЙ ТҮНЭЛ" хөтөлбөрийг үргэлжлүүлж, айл өрх бүр ангилан ялгагдаг хогийн савтай болох, хогийн цэгийг камержуулах ажлыг зохион байгуулна.



A handwritten signature in blue ink, consisting of a stylized, cursive set of letters.

0000000004